



ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ЦЭЦЭРЛЭГ

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Аудитын газрын дарга,
Тэргүүлэх Аудитор
Л.Жаргалсайхан
Утас: 70272582
[И-мэйл](#)

СТА-ын ахлах аудитор
Ц.Базарсад
Утас: 70272287
И-мэйл Bazaraatsend@yahoo.com

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4
• Гол шийдлүүд	7
• Залруулаагүй алдаа	7
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	7
• Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт.....	7
• Аудитын санал дүгнэлт	8

Сургуулийн өмнөх боловсролын 2013 оны Санхүүгийн тайланд

ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид СӨБ-ийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба СӨБ-ийн төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд цэцэрлэг тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

1. Байгууллагын дотоод хяналтыг 2011.03.02-ны өдрийн 17 тоот тушаалаар батласан байна. Дотоод хяналт шалгалтыг явуулах журмыг батласан гэх боловч төлөвлөгөө удирдамж гарган хийсэн хяналт шалгалт байхгүй байна.
2. цалингийн зардлаас 767.3 мянган төгрөгийн НДШимтгэл дутуу төлсөн актын төлбөрийг төлсөн байна.
3. Халаалтын зардлыг нарийвчилан тооцож үзэхэд НРЖ-25 тогооны цагийн нормоор нь нүүрсийг тооцоход 10 сард 1240тн, 11 сард 1900 тн нүүрс илүү зарцуулсаныг төлүүлэхээр шийдвэрлэсэн байна.
4. Мөнгөн гүйлгээний тайлангаар 221.7 мянган төгрөгийн зардал гаргаж, бичиг хэргийн материалын тайланд 1215.2 мянган төгрөгийн орлого авсаныг тулган шалгахад хичээл

- үйлдвэрлэлийн зардлаас 961.2 мянган төгрөг, ном хэвлэлийн зардлаас 61.6 мянган төгрөг, жижиг эд хогшлын зардлаас 36.0 мянган төгрөгүүдийг зардлын бүлэг хоорондын шилжүүлэг хийн зарцуулсан боловч төрийн сангийн зөвшөөрөл авалгүйгээр зарцуулсан.
5. Хоолны зардалд 44481.7 мянган төгрөгний зардал батлагдсан, гүйцэтгэлээр 44481.5 мянган төгрөгний зардал гаргаж, 0.2 төгрөг хэмнэгдсэнээр тайлагнасаных журналын бичилтээр хөөн шалгахад өмнөх оны хүнсний материалтай холбогдсон зөрчилд тавигдсан актын төлбөрт 1217.1 мянган төгрөг, цахилгааны зардалд 213.2 мянган төгрөг, усанд 421.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.
 6. Үр дүнгийн тайлангаар 43697.1 мянган төгрөг зарцуулсаныг журналаар нь хөөн шалгахад урьд оны актын барагдуулалтанд төлсөн 1217.1 мянган төгрөг, бараа материалын тайлангаар 42040.8 мянган төгрөгний хоол зарцуулж, усны зардалд 439.2 мянган төгрөгийн зарцуулсан байна.
 7. 2013 онд нийт 25928 хүүхэд өдөрт 42266.8 мянган төгрөгний хоолны зардал гаргажээ. Энэ нь нэг хүүхэд өдөрт 1630 төгрөгний зардал гаргаж, Засгийн газраас тогтоосон нэг хүүхэд өдрийн хоолны зардал 1650 төгрөгнөөс 20 төгрөгөөр буюу жилдээ нийт 518.6 мянган төгрөгөөр дутуу хооллосон байна.
 8. Цэцэрлэгийн хоолны зардал 997.6 мянган төгрөг хэмнэлтийг төвлөрүүлээгүй бүлэг хооронд нь шилжүүлэн зарцуулсан нь Сангийн сайдын 73-р тушаалын 5-д заасны дагуу зохицуулалт хийгээгүй, БСШУСайд, ССайдын 2009.12.14-ны 560/276 тоот

тушаалаар батлагдсан Хүүхдийн цэцэрлэгийн хоол, ерөнхий боловсролын цэцэрлэгийн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол, МСҮТөвийн сургалцагчдын тэтгэлэгийн зардлын хэмнэлтийг тооцох, төвлөрүүлэх, зарцуулах журмын 2-ын 4-д Төв төрийн сан дахь Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хэмнэлтийн дансанд зардлын хэмнэлтийг төвлөрүүлнэ, 6-д Цэцэрлэгийн эрхлэгч, цэцэрлэгийн захирал нь тухайн улиралд гарсан зардлын хэмнэлтийг дараа улирлын эхний сарын 10-ны дотор, 4-р улирлын зардлын хэмнэлтийг 12 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэх дансанд шилжүүлж байна гэснийг тус тус зөрчсөн байна.

Шууд захирагчаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

- Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа
- Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт 2014.03.14-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ерөнхий нягтлан бодогч Д.Төмөртоогоо бидэнтэй хамтран ажилласан ажилчдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**Үндэсний Аудитын Газрын харьяа
Төв Аймгийн Аудитын Газар**

2014.03.14

Танилцуулга

1. Бид Аймгийн Цээл сумын цэцэрлэгийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Аймгийн Цээл сумын цэцэрлэгийн ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Цээл сумын цэцэрлэг тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийхэд

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Аймгийн Цээл сумын цэцэрлэгийн хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Аймгийн Цээл сумын цэцэрлэгийн эрхлэгчид тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Аймгийн Цээл сумын цэцэрлэгийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн дотоод хяналтын талаар

Байгууллагын дотоод хяналтыг 2011.03.02-ны өдрийн 17 тоот тушаалаар батласан байна. Дотоод хяналт шалгалтыг явуулах журмыг батласан гэх боловч төлөвлөгөө удирдамж гарган хийсэн хяналт шалгалт байхгүй байна.

2. Орлогын талаар

Мөнгөн гүйлгээний тайлангаар урсгал санхүүжилт 230493.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг тайлагнагдсан. Санхүүгийн үр дүнгийн тайлангаар урсгал санхүүжилт 230493.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй авсан хөрөнгийн орлого 1939.0 мянган төгрөг, Бүгд 232432.4 мянган төгрөгийн эх үүсвэрээр тайлагнагдсан байна.

3. Мөнгөн хөрөнгийн талаар

Харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад төрийн сангийн данс 0 төгрөгийн үлдэгдэлтэй хяналтын хуулга байгаа боловч төрийн сан байгууллагын цэвэр мөнгөн гүйлгээний орлого, зарлага, үлдэгдлийг албан ёсоор өссөн дүнгээр баталгаажуулдаггүй байна.

Хяналтын түвшингийн хуулгаар урсгал санхүүжилт 230493.4 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний цэвэр зарлага 246232.5 мянган төгрөг, орлогоос бууруулах бичилтээр

15744.8 мянган төгрөг тайлагнагдахыг мөнгөн гүйлгээний журналд бичилгүйгээр шууд орхин тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаар 221.7 мянган төгрөгийн зардал гаргаж, бичиг хэргийн материалын тайланд 1215.2 мянган төгрөгийн орлого авсаныг тулган шалгахад хичээл үйлдвэрлэлийн зардлаас 961.2 мянган төгрөг, ном хэвлэлийн зардлаас 61.6 мянган төгрөг, жижиг эд хогшлын зардлаас 36.0 мянган төгрөгүүдийг зардлын бүлэг хоорондын шилжүүлэг хийн зарцуулсан байна.

Аж ахуйн материалд 1619.8 мянган төгрөгийн орлого авсаныг шалгахад урсгал засварын зардлаас 366.0 мянган төгрөг, биеийн тамир уралдаан тэмцээний зардлаас 86.5 мянган төгрөг, жижиг эд хогшлын зардлаас 18.3 мянган төгрөг, шагнал урамшууллын зардлаас 120.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Түлш халаалтын зардлаас Ану сервист 2140.2 мянган төгрөг, уурын зуухны моторын үнэнд 170.0 мянган төгрөг, цахилгааны зардалд 979.2 мянган төгрөг зардлын бүлэг хооронд нь гүйлгэн зарцуулсан байна.

Анхан шатны баримтын бүрдэлгүй хийсэн гүйлгээнүүдийг шалгахад 316.3 мянган төгрөгийн бараа материалын үнэ, 133.7 мянган төгрөгийн шатахууны үнэ, 7479.4 мянган төгрөгийн хүнсний материалын үнийг нэхэмжлэхгүй шилжүүлсэн байна.

Иргэн хүнээс 45816.8 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч ХХАОАТ суутгаагүй, татварын цэнхэр дэвтэрт бичилт хийж хавсаргаагүй байна.

Хоолны зардлаас 213.2 мянган төгрөгийн цахилгааны төлбөрийг төлж зориулалт бус зардал гаргасан төрийн сангаас зөвшөөрөл аваагүй байна. 3 сарын 27-нд аймагт томилолтоор ажилласан Б.Атарцэцэг, Д.Бямбасүрэн нарт гүйцэтгэх ажлын удирдамж, ажил гүйцэтгэсэн тухай тайлан, дүгнэлт, олгохыг зөвшөөрсөн гарын үсэггүй томилолтын хуудсаар 100 мянган төгрөгийн томилолт олгосон, олговол зохих томилолтын үнийн дүнгээс 56.0 мянган төгрөгийг илүү бодож олгосоныг акт бичигдэж төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

Хугацаа хэтэрсэн төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийсэн, 5 сарын 21-нд төлбөрийн хүсэлт бичигдсэн байхад төрийн сан 5 сарын 20-нд хянаж батлагаажуулсан нь анхан шатны баримтанд тавих хяналт муу байгааг харуулж байна.

Бараа материалыг анхан шатны баримттай тулгахад 1 тн нүүрсийг илүү орлогод авч 130.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн, 416.0 мянган төгрөгийг дансанд тусгаагүй байна.

Цахилгааны нэхэмжлэхээр 2950.2 мянган төгрөг шилжүүлж өр авлагын дансаар дамжуулалгүйгээр шууд зардалд хийсэн байна. Цахилгааны зардал хүрэхгүйгээс халаалтын зардлаас 1406.8 мянган төгрөг, хоолноос 213.2 мянган төгрөг гүйлгэн зарцуулсан боловч зохицуулалтын эрхийн баталгаа хийгдээгүй, зардал хоорондын хэтрэлт хэмнэлтийг буруу тооцсон байна.

Хоолны зардалд 44481.7 мянган төгрөгний зардал батлагдсан, гүйцэтгэлээр 44481.5 мянган төгрөгний зардал гаргаж, 0.2 төгрөг хэмнэгдсэнээр тайлагнасаныг журналын бичилтээр хөөн шалгахад өмнөх оны хүнсний материалтай холбогдсон зөрчилд тавигдсан актын төлбөрт 1217.1 мянган төгрөг, цахилгааны зардалд 213.2 мянган төгрөг, усанд 421.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Үр дүнгийн тайлангаар 43697.1 мянган төгрөг зарцуулсаныг журналаар нь хөөн шалгахад урьд оны актын барагдуулалтанд төлсөн 1217.1 мянган төгрөг, бараа материалын тайлангаар 42040.8 мянган төгрөгний хоол зарцуулж, усны зардалд 439.2 мянган төгрөгийн зарцуулсан байна.

2013 онд нийт 25928 хүүхэд өдөрт 42266.8 мянган төгрөгний хоолны зардал гаргажээ. Энэ нь нэг хүүхэд өдөрт 1630 төгрөгний зардал гаргаж, Засгийн газраас тогтоосон нэг

хүүхэд өдрийн хоолны зардал 1650 төгрөгнөөс 20 төгрөгөөр буюу жилдээ нийт 518.6 мянган төгрөгөөр дутуу хооллосон байна.

4. Бараа материалын талаар

Бараа материалын оны эхний үлдэгдэл 9130.9 мянган төгрөг, тайланд онд нэмэгдсэн 68273.8 мянган төгрөг, 67462.7 мянган төгрөг зарцуулж, 9942.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Халаалтын зардлыг нарийвчилан тооцож үзэхэд НРЖ-25 тогооны цагийн нормоор нь нүүрсийг тооцоход 10 сард 1240тн, 11 сард 1900 тн нүүрс илүү зарцуулсан байна.

Орлого зарлагын баримтыг дугаарлаагүй нь СЭЗС, ҮСГ-ын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралтаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан гатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 1-7-д Аж ахуйн нэгж, байгууллага нь анхан шатны маягтуудыг нэгдсэн журмаар урьдчилан дугаарлана гэснийг зөрчсөн байна.

5. Үндсэн хөрөнгийн талаар

Тайлант онд оны эхний үлдэгдэл 564973.5 мянган төгрөг, хандив тусламжаар 1939.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж авч, оны эцсийн үлдэгдэл 566912.5 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Жилийн эцсийн тооллогын комиссыг цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар нийгмийн ажилтан Л.Байнгынжаргал, дуу хөгжмийн багш Ё.Мөнхцэцэг, туслах багш Ц.Оюун-эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэйгээр 2013.12.15-ны өдрөөс 10 хоногийн дотор тооллогыг хийж дуусган комиссын хурлаар хэлэлцэн холбогдох материалыг 2013.12.25-нд нягтлан бодогчид ирүүлсэн байхаар тушаал гарсан байна. Гэтэл тооллогын комиссын нэгтгэл, хурлаар хэлэлцүүлсэн материал байхгүй, тооллогын бүртгэл нь программаас тооллогын бүртгэлийн маягтыг эхсэл файлруу хөрвүүлсэн материал дээр тоолсон гэсэн нүдэнд алдаг оног хөтөлсөн, ихэнх тооллогын бүртгэл нь үлдэгдэлээр нь ирүүлсэн учраас тооллого хийсэн гэж үзэх үндэслэлгүй байна.

Хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа хийхээр хуульд заасан боловч тооллогыг дээрх маягаар хийнэ чанартай хийдэггүй байна.

Элэгдлийг санхүүгийн программаар бодуулж бичилтийг хийж гүйцэтгэсэн байна.

6. Авлага, өглөгийн талаар

Тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан эсэхийг шалгахад Цахилгаан шугам сүлжээний газартай 2950.2 мянган төгрөгийн зардлын бичилт, төлөлтийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар ажил олгогчоос төлөх НДШимтгэлд 14788.2 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 14745.3 мянган төгрөгний НДШ-ийн зардал гарч, батлагдсан зардал 42.9 мянган төгрөгөөр хэмнэгдсэн харагдаж байна.

2013 онд НДСанд ажил олгогчоос 14745.2 мянган төгрөг, даатгуулагчаас 13404.7 мянган төгрөг, бүгд 28149.9 мянган төгрөг, өмнөх оны авлага 36.6 мянган төгрөг, нийт 28149.9 мянган төгрөгний НДШимтгэл төлөхөөс 28149.9 мянган төгрөг төлж, 36.6 мянган төгрөгний урьд оны шимтгэлийн илүү төлөлтийг тайланд тусгаагүй байна.

7. Цалингийн талаар

Цалин, үр дүнгийн урамшил, гэрээт ажилтны цалин зэрэгт нийт 134832.9 мянган төгрөгний зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 134814.9 мянган төгрөгний цалин, хөлс, урамшил олгож батлагдсан зардлаас 17.9 мянган төгрөгийг хэмнэсэн байна. Гэвч цалингийн зардлаас 767.3 мянган төгрөгийн НДШимтгэл дутуу төлсөн актын төлбөрийг төлсөн байна.

Ажилтнуудад Үр дүнгийн урамшууллыг олгохоор гаргасан тушаалдаа ажлыг нь дүгнэсэн дүгнэлтийнхээ товчоог хавсаргаагүй, зарим ажилтнуудад улиралд үндсэн цалингийнх нь 30-45 хувиар бүх хүндээ улирал бүр олгосон байна

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 7 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

6. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- + Зардлын бүлэг хооронд гүйлгэн шилжүүлэхдээ төрийн сангийн зөвшөөрлийг авч ЗЭБ-1 маягтаар баталгаажуулан гүйлгээ хийж байх
- + Хоорондын тооцоо бүрийг улирлын эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулж хэвших
- + Тооцоо бодолт, тооллогыг цаг тухай бүрд нь чанартай хийж гүйцэтгэж байх
- + Сар бүр харилцахын журналыг анхан шатны баримтанд хэвлэж үдэж байх
- + Харилцах, кассын баримтын оны эхнээс нэг дугаараар дугаарлаж хэвших
- + Бараа материалын тайлангаас дутагдсан 85.0 мянган төгрөгийн банзыг төлүүлэхээр акт бичигдсэн.
- + НДШ-ийн авлага 36.6 мянган төгрөгийг татан төвлөрүүлэхээр акт бичигдсэн.

7. Эдгээр асуудлуудыг ААГ болон Цээл сумын цэцэрлэг авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

8. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг.

Тайлбар мэдүүлгийн захидал

9. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд цэцэрлэгийн удирдлагаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

10. Аймгийн Аудитын газраас тус тайланд зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

**Үндэсний Аудитын Газрын харьяа
Төв Аймгийн Аудитын Газар
2014.03.14**

